

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/018/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас:260512 Цахим хаяг:natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Батсүх
Утас: 261885 Цахим хаяг: batsukhts@audit.gov.mn
Аудитор: Б.Батхишиг
Утас: 261885 Цахим хаяг: batkhishigb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	21
4. АУДИТЫН ТАЙЛАН	24
4.1 Ерөнхий зүйл	24
4.2 Материаллаг байдал.....	24
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	24
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	25
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	25
4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	26
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	27
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	28
5.1 Харьяа орон нутгийн байгууллагууд	28
5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан	29
Албан шаардлага	29
5.3 Түүврийн байгууллага	31
5.3.1 Төлбөрийн акт	31
5.3.2 Албан шаардлага	32
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	37
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	37
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	38
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	39
6.4 Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдалт	40

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСГ	Биеийн тамир, спортын газар
БТСХ	Биеийн тамир, спортын хороо
БТСУХ	Биеийн тамир, спортын Улсын хороо
САУЭШТ	Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН
ХОРООНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.БИЛЭГТ
ТАНАА

2025.03.25 № 01/1213
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нийт 18,667.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархсан байна. Тухайлбал:

- Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн 18,667.7 сая төгрөгийн, нийцлийн аудитын 8,770.6 сая төгрөгийн нийт 27,438.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн;
- Спортын холбоодод эхний хагас жилийн байдлаар 15,409.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг улсын төсвөөс олгосон боловч гэрээний биелэлтийг холбоо бүрээр дүгнэж баталгаажуулаагүй, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс болон дотоод аудитын хэлтсээс гүйцэтгэлийг дүгнэж, баталгаажуулаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 561.7 сая төгрөгийн авлага барагдуулаагүй;
- Хэлэлцүүлэг, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж харьяа 10 байгууллага 422.9 сая төгрөгийг зарцуулсан.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга ба тодруулга”, “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн төвлөрүүлэн захирагчийг шинэчлэн батлах тухай” 2024 оны 110 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын улсын хорооны дарга нь Биеийн тамир, спортын улсын хороо, орон нутаг дахь биеийн тамир, спортын газар, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Спортыг дэмжих сангийн төвлөрүүлэн захирагч болсон байна.

Тайлант онд Спортыг дэмжих санд үйл ажиллагаа явуулах төсөв батлагдсан боловч гүйцэтгэл гараагүй, Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ уг тогтоолд тусгагдаагүй тул нэгтгэсэн тайланд хамрагдаагүй байна.

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia системд “Спортын цолны лавлагаа” цахим үйлчилгээг тайлант онд нэвтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын бүтцийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд шилжсэнээр бусад эргэлтийн хөрөнгө 165,908.9 сая төгрөгөөр буурсан байна.

Дархан-Уул аймагт 2200 хүний суудалтай спорт цогцолбор, Налайх дүүрэгт 700 хүний суудалтай спорт цогцолбор шинээр ашиглалтад орсон.

Биеийн тамир спортын улсын хороо үндсэн үйл ажиллагааны зардалд 4,205.2 сая төгрөг төсөвлөснөөс 4,197.9 сая төгрөг, нийтийн биеийн тамирын арга хэмжээний зардалд 929.9 сая төгрөг төсөвлөснөөс 713.7 сая төгрөг, олимп, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчдын зардалд 1,896.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудал

Биеийн тамир, спортын улсын хорооны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй, аудитын цар хүрээнд удирдлагын хязгаарлалтын улмаас хангалттай ба зохистой нотолгоо олж авах боломжгүй ч энэхүү тайлангийн хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлыг толилуулж байна.

Бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 3-64 насны иргэдийн биеийн үндсэн ачаалал даах чадварыг хянах зорилгоор зохион байгуулахад 345,163 иргэн хамрагдсанаас 47.7 хувь нь А, В үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САМБУУНЯМ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	187,311,104.0	15,295,607.8
МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,182,045.6	23,144.7
АВЛАГА	1,866,659.1	657,359.1
УРЬДЧИЛГАА	4,082,080.5	3,776,338.7
БАРАА МАТЕРИАЛ	3,924,220.0	4,491,657.0
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	172,256,098.9	6,347,108.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	144,546,871.6	162,595,368.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	144,546,871.6	162,595,368.2
Биет хөрөнгө	131,324,143.6	148,889,035.6
Биет бус хөрөнгө	13,222,727.9	13,706,332.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	331,857,975.6	177,890,976.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,344,991.7	270,743.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,344,991.7	270,743.4
Өглөг	5,344,991.7	270,743.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	326,512,983.9	177,620,232.6
Засгийн газрын хувь оролцоо	326,512,983.9	177,620,232.6
Засгийн газрын оруулсан капитал	53,863,018.9	55,031,145.7
Хуримтлагдсан үр дүн	252,505,687.6	102,445,466.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,144,277.5	20,143,620.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	331,857,975.6	177,890,976.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	265,777,268.4	104,755,205.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	151,118,775.8	23,683,179.9
Нийтлэг татварын бус орлого	151,118,775.8	23,683,179.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	114,658,492.6	81,072,025.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	82,503,519.3	86,705,459.3
УРСГАЛ ЗАРДАЛ	82,503,519.3	86,705,459.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,367,241.9	79,094,577.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,031,957.7	21,956,197.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,849,008.2	2,686,233.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,445,971.5	243,694.9
Хангамж, бараа материалын зардал	929,262.9	1,045,526.8
Нормативт зардал	250,932.2	482,568.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,155,245.5	832,263.9
Томилолт, зочны зардал	129,715.1	75,785.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,145,228.0	30,823,040.4
Бараа үйлчилгээний бусад зардал	26,260,661.4	20,949,265.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,305,536.9	7,610,882.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	183,273,749.1	18,049,746.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	23,325.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,028,103.8	588,890.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	180,245,645.3	17,484,180.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	125,483,748.5	81,569,100.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,634,845.9	270,115.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	115,848,902.6	81,298,985.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	85,677,004.1	85,205,940.8
УРСГАЛ ЗАРДАЛ	85,677,004.1	85,205,940.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,563,715.2	77,634,971.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,042,020.9	22,076,879.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,854,910.0	2,686,142.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,344,789.0	242,406.8
Хангамж, бараа материалын зардал	529,032.3	470,737.7
Нормативт зардал	144,764.2	1,512,401.7
Эд хогшил, урсгал засварын зардал	2,101,611.2	1,638,705.4
Томилолт, зочны зардал	131,434.8	75,278.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,833,548.8	29,746,850.6
Бараа үйлчилгээний бусад зардал	27,581,604.0	19,185,569.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,113,288.9	7,570,969.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	39,806,744.4	(3,636,840.0)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,624,698.8	1,522,060.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,624,698.8	1,522,060.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(34,624,698.8)	(1,522,060.9)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,182,045.6	(5,158,900.9)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,182,045.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,182,045.6	23,144.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,863,018.9	20,144,277.5	72,260,042.3	146,267,338.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,863,018.9	20,144,277.5	72,260,042.3	146,267,338.7
Тайлант үеийн үр дүн			180,245,645.3	180,245,645.3
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,863,018.9	20,144,277.5	252,505,687.6	326,512,984.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,168,126.8	(657.4)	(167,544,401.7)	(166,376,932.3)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,031,145.7	20,143,620.1	84,961,285.9	160,136,051.7
Тайлант үеийн үр дүн			17,484,180.8	17,484,180.8
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	55,031,145.7	20,143,620.1	102,445,466.7	177,620,232.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,395,836,500.00	67,411,182,760.12	4,984,653,739.88	93.1
УРСГАЛ ЗАРДАЛ	72,395,836,500.00	67,411,182,760.12	4,984,653,739.88	93.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,505,488,700.00	62,546,899,866.07	4,958,588,833.93	92.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,321,751,200.00	20,166,179,609.64	1,155,571,590.36	94.6
Үндсэн цалин	11,896,692,300.00	11,773,424,416.56	123,267,883.44	99.0
Нэмэгдэл	6,382,417,800.00	5,032,371,939.54	1,350,045,860.46	78.8
Унаа хоолны хөнгөлөлт	1,484,016,500.00	1,941,082,867.26	(457,066,367.26)	130.8
Урамшуулал	1,558,624,600.00	1,416,484,400.28	142,140,199.72	90.9
Гэрээт ажлын хөлс	-	2,815,986.00	(2,815,986.00)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,665,225,100.00	2,479,118,777.28	186,106,322.72	93.0
Тэтгэврийн даатгал	1,812,353,100.00	1,703,391,420.72	108,961,679.28	94.0
Тэтгэмжийн даатгал	213,218,100.00	202,046,200.85	11,171,899.15	94.8
ҮОМШӨ-ний даатгал	107,743,600.00	104,697,622.53	3,045,977.47	97.2
Ажилгүйдлийн даатгал	105,474,300.00	93,476,229.64	11,998,070.36	88.6
Эрүүл мэндийн даатгал	426,436,000.00	375,507,303.54	50,928,696.46	88.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	226,151,300.00	226,151,300.00	-	100.0
Гэрэл, цахилгаан	104,212,400.00	104,212,400.00	-	100.0
Түлш, халаалт	85,755,500.00	85,755,500.00	-	100.0
Цэвэр, бохир ус	36,183,400.00	36,183,400.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	347,271,100.00	333,383,282.94	13,887,817.06	96.0
Бичиг хэрэг	47,313,600.00	49,444,274.05	(2,130,674.05)	104.5
Тээвэр, шатахуун	75,569,100.00	71,346,439.00	4,222,661.00	94.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64,113,700.00	62,265,743.06	1,847,956.94	97.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,086,000.00	27,627,393.00	3,458,607.00	88.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	129,188,700.00	122,699,433.83	6,489,266.17	95.0
Нормативт зардал	1,777,991,800.00	1,509,322,708.68	268,669,091.32	84.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	418,558,600.00	418,558,522.00	78.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,359,433,200.00	1,090,764,186.68	268,669,013.32	80.2
Эд хогшил, урсгал засварын зардал	2,372,560,500.00	2,328,532,603.00	44,027,897.00	98.1
Багаж, техник, хэрэгсэл	1,594,260,100.00	1,538,169,295.00	56,090,805.00	96.5
Тавилга	46,956,000.00	46,938,000.00	18,000.00	100.0
Урсгал засвар	731,344,400.00	743,425,308.00	(12,080,908.00)	101.7
Томилолт, зочны зардал	76,450,200.00	67,060,640.00	9,389,560.00	87.7
Дотоод албан томилолт	76,450,200.00	67,060,640.00	9,389,560.00	87.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,944,270,800.00	29,109,271,348.11	1,834,999,451.89	94.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,829,219,200.00	29,016,825,664.27	1,812,393,535.73	94.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	18,428,000.00	11,309,400.00	7,118,600.00	61.4
Даатгалын үйлчилгээ	9,981,200.00	8,433,344.00	1,547,856.00	84.5
Тээврийн хэрэгслийн татвар	3,349,600.00	1,686,493.00	1,663,107.00	50.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,340,000.00	523,700.00	816,300.00	39.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,620,700.00	24,234,899.84	1,385,800.16	94.6
Газрын төлбөр	56,332,100.00	46,257,847.00	10,074,253.00	82.1
Бараа үйлчилгээний бусад зардал	7,773,816,700.00	6,327,879,596.42	1,445,937,103.58	81.4

Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	7,701,212,200.00	6,267,239,662.42	1,433,972,537.58	81.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,604,500.00	60,639,934.00	11,964,566.00	83.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,890,347,800.00	4,864,282,894.05	26,064,905.95	99.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	117,905,600.00	113,905,638.00	3,999,962.00	96.6
Засгийн газрын гадаад шилжүүлэг	117,905,600.00	113,905,638.00	3,999,962.00	96.6
Бусад урсгал шилжүүлэг	4,772,442,200.00	4,750,377,256.05	22,064,943.95	99.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	76,380,000.00	76,380,000.00	-	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,847,137,200.00	3,844,170,000.00	2,967,200.00	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	522,268,000.00	509,011,747.05	13,256,252.95	97.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	215,206,800.00	215,206,679.00	121.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,450,200.00	105,608,830.00	5,841,370.00	94.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,395,836,500.00	67,592,327,910.12	4,803,508,589.88	93.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,395,836,500.00	67,363,521,310.12	5,032,315,189.88	93.0
Улсын төсвөөс санхүүжих	72,395,836,500.00	67,363,521,310.12	5,032,315,189.88	93.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	228,806,600.00	(228,806,600.00)	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	191,329,150.00	(191,329,150.00)	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	37,477,450.00	(37,477,450.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,182,045,600.00	5,182,045,600.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	23,144,688.80	23,144,688.80	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	33	33	0	100.0
Төсвийн байгууллага	33	33	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	923	862	61	93.4
Удирдах ажилтан	37	34	3	91.9
Гүйцэтгэх ажилтан	562	522	40	92.9
Үйлчлэх ажилтан	324	306	18	94.4
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	923	862	61	93.4
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	98	96	2	98.0
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	8	8	-	100.0
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	357	315	42	88.2
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	13	13	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	447	430	17	96.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	12,988,523,546.22
УРСГАЛ ЗАРДАЛ	-	12,930,913,928.22
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	12,284,493,898.53
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,910,699,496.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	207,023,382.18
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	16,255,540.32
Хангамж, бараа материалын зардал	-	140,546,421.00
Нормативт зардал	-	3,520,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	297,930,740.00
Томилолт, зочны зардал	-	8,217,660.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,783,474,909.53
Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,916,825,749.50
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	646,420,029.69
Бусад урсгал шилжүүлэг	-	382,370,722.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	264,049,307.69
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	57,609,618.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	12,988,523,546.22
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	52,023,000.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,571,940,536.98
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,428,311,590.24
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,936,248,419.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Биеийн тамир, спортын улсын хороо нь эрхэм зорилгоо “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд хамаарах биеийн тамир, спортын салбарын үндсэн зорилт, чиг үүрэг болох иргэд биеийн тамир, спортоор хичээллэх олон талт боломжийг бүрдүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, спортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үндэсний спортын өв соёлыг хамгаалж өвлүүлэх, шинжлэх ухаан, технологийн үр нөлөөг нэмэгдүүлж, спортын ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хүн амын амьдралын чанарыг сайжруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Биеийн тамир, спортын улсын хороо нь үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх;
- Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барих;
- Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах;
- Биеийн тамир, спортын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;
- Биеийн тамир, спортын салбарын болон хорооны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Биеийн тамир, спортын улсын хороо нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,
- Төсвийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,
- Биеийн тамир, спортын тухай хууль /шинэчилсэн найруулга/,
- Хөдөлмөрийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль /нэмэлт оруулах тухай/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,

Мөн Биеийн тамир, спортын салбарын төрийн мэдээллийн цахим сангаас Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia.mn системд “Спортын цолны лавлагаа” цахим үйлчилгээ бий болгох ажлыг холбогдох байгууллагуудыг хамруулан зохион байгуулж, 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр [e-mongolia](http://e-mongolia.mn) системд “Спортын цолны лавлагаа” цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын албанаас Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны 3 дугаар улирлын байдлаар төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд 5,558.5 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илрүүлж дотоод хяналтыг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч тайланд дурдагдсан асуудлыг гэмт хэргийн шинжтэй гэж үзэн АТГ-т шилжүүлсэн ч тус хорооны холбогдох ажилтнуудаас улсын байцаагчийн тайлан дүгнэлттэй холбоотой гомдол гаргасан байна.

Биеийн тамир, спортын улсын хорооны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хорооны 2021 онд батлагдан мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу бүрэн бэлтгээгүй байсныг аудитын явцад залруулах санал хүргүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тус хорооны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй.

Санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өмнөх оноос 153,967.0 сая төгрөгөөр буюу 46.4 хувиар буурсан байна. Энэ нь Спортын салбарын хөрөнгө оруулалт, их засвар болон Үндэсний шигшээ багын бэлтгэл сургалтын төв байгууллагууд шилжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,182,045.6	23,144.7	(5,158,900.9)
Авлага	1,866,659.1	657,359.1	(1,209,300.0)
Урьдчилгаа	4,082,080.5	3,776,338.7	(305,741.8)
Бараа материал	3,924,220.0	4,491,657.0	567,437.0
Бусад эргэлтийн хөрөнгө	172,256,098.9	6,347,108.4	(165,908,990.5)
Үндсэн хөрөнгө	144,546,871.6	162,595,368.2	18,048,496.6
Нийт хөрөнгө	331,857,975.6	177,890,976.0	(153,966,999.6)
Өр төлбөр	5,344,991.7	270,743.4	(5,074,248.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	326,512,983.9	177,620,232.6	(148,892,751.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	331,857,975.6	177,890,976.0	(153,966,999.6)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитад хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн данс 23.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	1,877.0	1,877.0
Төрийн сангийн харилцах	5,182,036.2	21,267.7	(5,160,768.5)
Арилжааны банк дахь харилцах	9.4	-	(9.4)
Дүн	5,182,045.6	23,144.7	(5,158,900.9)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 91.8 хувь нь аппаратын харилцах дансны үлдэгдэл, 8.2 хувийг касс дахь бэлэн мөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Биеийн тамир спортын арга хэмжээнд зориулсан цом, өргөмжлөл, батламж хэвлэмэл материал бэлтгэхэд нэг аж ахуй нэгж байгууллагаас төсөвт өртгийн дээд хязгаараас давсан 32.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. /Хан-Уул дүүргийн БТСГ 32.2 сая төгрөг/

-Биеийн тамир спортын зарим хөтөлбөр арга хэмжээний төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийн тайланд анхан шатны бүрдэл дутуу баримтаар 19.6 сая төгрөгийн гүйлгээ хийж, зардалд тооцсон байна. /Хан-Уул дүүргийн БТСГ 19.6 сая төгрөг/

-Төсвийн захирагчийн мөнгөн гүйлгээний зарцуулалтыг нэгдсэн цахим системийн дүнтэй тулган шалгахад 45.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна. /БТСУХ 45.8 сая төгрөг/

3.4.2 Авлага

Авлага данс 657.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Ажиллагчидтай холбогдсон авлага	3,292.4	4,647.6	1,355.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	94,145.5	152,866.8	58,721.3
Татаас, санхүүжилтийн авлага	3,849.7	400.0	(3,449.7)
Байгууллагаас авах авлага	1,758,921.8	492,995.0	(1,265,926.8)
Хувь хүмүүсээс авах авлага	6,449.7	6,449.7	-
Дүн	1,866,659.1	657,359.1	(1,209,300.0)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд БТСУХ-ны авлага 85.4 хувь, Говь-Алтай БТСГ-ын авлага 5.8 хувь, Дорноговь БТСГ-ын авлага 4.1 хувь, Ховд БТСГ-ын авлага 2.8, бусад байгууллагууд 1.9 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

-Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 657,359.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. /БТСУХ 561.7 сая төгрөг, БХД-ийн БТСГ 3.3 сая, Баян-Өлгий БТСГ 0.5 сая, Говь-Алтай БТСГ 38.1 сая төгрөг, Дундговь БТСГ 2.2 сая, Дорнод БТСГ 27.3 сая, Завхан БТСГ 1.5 сая, Орхон БТСГ 0.7 сая, Хан-Уул дүүргийн БТСГ 0.9 сая, Чингэлтэй дүүргийн БТСГ 0.9 сая төгрөг, Ховд аймгийн БТСГ 18.4 сая төгрөг, Хөвсгөл аймгийн БТСГ 0.1 сая, Өвөрхангай аймгийн БТСГ 0.1 сая төгрөг, Өмнөговьд аймгийн БТСГ 0.6 сая төгрөг /

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс 3,776.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа	4,082,080.5	3,776,338.7	(305,741.8)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл нь БТСУХ-ны 3,776.3 сая төгрөг байна.

Үндэсний олимпын хороо, Монголын тусгай олимпийн хороо болон Үндэсний шигшээ багийн 14 холбооны тэмцээн уралдааны санхүүжилт 3,776.3 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар тайлагнасантай холбоотой байна.

3.4.4 Бараа материал

Бараа материал данс 4,491.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 5. Бараа материал үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Түүхий эд материал	1,961,074.4	2,156,079.4	195,005.0
Дуусаагүй үйлдвэрлэл	-	98,894.7	98,894.7
Бэлэн бүтээгдэхүүн	12,106.2	7,375.0	(4,731.2)
Хангамжийн материал	1,045,671.6	1,261,706.4	216,034.8
Бусад хангамжийн материал	905,367.8	967,646.6	62,278.8
Дүн	3,924,220.0	4,491,657.0	567,437.0

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэлд аймгуудын БТСУХ-ны үлдэгдэл 28.0 хувь, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн үлдэгдэл 6.1 хувь, орон нутгийн БТС газар, хороодын үлдэгдэл 65.9 хувийг эзэлж байна. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй Дорнод аймгийн орон нутгийн санхүүжилтээр байгууллагын гадаах зогсоолын ажлыг хийсэн бөгөөд ажил дуусаагүй улмаас дээрх дансанд бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын тайланг материалын нэр төрлөөр бүрээр бүрэн хөтлөөгүй /БНД БТСХ 4.9 сая төгрөг/

Тайлант хугацаанд 97.4 сая төгрөгийн бараа материалын зарцуулалтын тайлан гаргахдаа орлого, зарлагын баримт, шаардах хуудсыг байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж баталгаажуулаагүй /Өмнөговь аймгийн БТСХ 4.9 сая төгрөг/

Тайланд тусгасан 37.0 сая төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй /Өмнөговь аймгийн БТСХ 37.0 сая төгрөг/

Тайлант онд 103.5 сая төгрөгийн бараа материал акталсан боловч өмч хамгаалах байнгын зөвлөл, устгалын ажлын хэсгийн тайлан байхгүй, бараа материалыг акталж устгасан эсэх нь баримтаар нотлогдохгүй /Өмнөговь аймгийн БТСХ 103.5 сая төгрөг/

Тайлант хугацаанд 2.3 сая төгрөгийн шатахуун зарцуулалтад тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудсыг бөглөж, баталгаажуулаагүй/ Өмнөговь аймгийн БТСХ 4.9 сая төгрөг/

Шатахууны тооцооллыг шалгахад норм нормативыг илүү тооцож 0.2 сая төгрөгийн шатахуун илүү бодож олгосон /Булган аймгийн БТСХ 0.2 сая төгрөг/

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө данс 6,347.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бусад эргэлтийн хөрөнгө,бусад /ТӨҮГ/	172,256,098.9	6,347,108.4	(165,908,990.5)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 165,908.9 сая төгрөгөөр буурсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалт их засвар яаманд шилжсэнтэй холбоотой байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн данс элэгдлийг хассан цэвэр дүн 162,595.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгө үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Биет хөрөнгө	131,324,143.8	148,889,035.4	17,564,891.6
Барилга, байгууламж, орон сууц	105,569,974.3	126,565,674.7	20,995,700.4
Авто-тээврийн хэрэгсэл	605,736.0	767,479.7	161,743.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,563,716.2	7,823,488.6	4,259,772.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,410,135.0	3,441,755.9	1,031,620.9
Зам, гүүрийн байгууламж	301,232.0	214,234.6	(86,997.4)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	514,200.0	514,200.0	-
Бусад үндсэн хөрөнгө	4,964,042.5	6,752,943.0	1,788,900.5
Дуусаагүй барилга, байгууламж	13,393,263.9	2,807,470.0	(10,585,793.9)
Ном	1,843.9	1,788.9	(55.0)
Биет бус хөрөнгө	13,222,727.9	13,706,332.5	483,604.6
Программ хангамж	48,623.4	335,181.7	286,558.3
Бусад биет бус хөрөнгө	13,174,104.5	13,371,150.8	197,046.3
Дүн	144,546,871.6	162,595,368.2	18,048,496.6

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18,048.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь:

- Дархан-Уул аймгийн БТСГ 2200 хүний суудалтай 36,360.4 сая төгрөгийн дүнтэй спорт цогцолбор, Налайх дүүргийн БТСХ 700 хүний суудалтай 15,025.7 сая төгрөгийн дүнтэй спорт цогцолбор тус тус ашиглалтад орж нэмж бүртгэсэн нь голлон нөлөөлжээ.
- Худалдаж авсан 984.4 сая төгрөгийн хөрөнгөд машин тоног төхөөрөмж 126.8 сая төгрөг, тавилга эд хогшил 44.0 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 778.6 сая төгрөг, программ хангамж 35.0 сая төгрөгийн хөрөнгүүд байна.
- Үндсэн хөрөнгө данснаас худалдсан, акталсан, шилжүүлсэн, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн, дахин үнэлгээний хорогдол зэрэг нийт 1,034.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

-Цахим дэлгүүрээс үндсэн хөрөнгө худалдан аваагүй./Говь-Алтай аймгийн БТСХ 5.6 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн БТСХ 112.9 сая төгрөг /

-Тайлант онд спорт заалны сандал шинэчлэх ажлын санхүүжилтийг урьдчилан олгосон, уралдаан тэмцээний шагналын медалийг бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зарлаагүй зэрэгтэй холбоотой 39.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. /Ховд аймгийн БТСХ 39.9 сая төгрөг /

-Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй. /БТСУХ 1,904.7 сая төгрөг, Хан-Уул дүүргийн БТСГ 2.5 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн БТСХ 116.2 сая төгрөг/

-Тайлант оны хагас болон бүтэн жилийн тооллогыг чанартай хийгээгүй, тайлант онд нэмэгдсэн 24.6 сая төгрөгийн хөрөнгийг эзэнжүүлээгүй, эд хөрөнгө эзэмшигчийн картыг хөтөлж баталгаажуулаагүй байна. /Багахангай дүүргийн БТСГ 24.6 сая төгрөг/

-хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн /Сонгинохайрхан дүүргийн БТСХ 7.8 сая төгрөг/

Хөрөнгийг бөөн дүнгээр тайлагнасан /Сонгинохайрхан дүүргийн БТСХ 45.7 сая төгрөг/

Худалдан авалтын төлөвлөгөө, гэрээ tender.gov.mn шилэн дансанд ил тодоор мэдээлээгүй /Сонгинохайрхан дүүргийн БТСХ/

-Ажилтан, албан хаагчдын ашиглаж буй эд хөрөнгийг дахин давтагдашгүй кодоор бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллаагүй бөгөөд өмчийн хадгалалт, хамгаалалт, хяналтын зохион байгуулалт хангалтгүй байна /Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв/

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөрийн данс 270.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Ажилчидтай холбогдсон өглөг	-	519.8	(519.8)
Байгууллагад төлөх өглөг	5,343,528.5	269,430.4	(5,074,098.1)
Хувь хүмүүст төлөх өглөг	1,463.2	793.2	(670.0)
Дүн	5,344,991.7	270,743.4	(5,074,248.3)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 10 байгууллагатай холбоотой бөгөөд Баян-Өлгий аймгийн БТСГ-ын үлдэгдэл 38.6 хувь, Увс аймгийн БТСГ-ын үлдэгдэл 20.2 хувь, Говь-Алтай аймгийн БТСГ-ын 35.2 хувь, Сонгинохайрхан дүүргийн БТСХ 4.3 хувь, бусад 6 байгууллагын үлдэгдэл 1.7 хувийг тус тус эзэлж байна. Өр төлбөр 5,074.2 сая төгрөгөөр буурсан нь спортын салбарын хөрөнгө оруулалт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам руу шилжсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

-Хөвсгөл аймгийн БТСГ 1.3 сая төгрөгийн өглөгийг тайланд дутуу тайлагнасан.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо данс 177,620.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Засгийн газрын оруулсан капитал	53,863,018.9	55,031,145.7	1,168,126.8
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	252,505,687.6	102,445,466.7	(150,060,220.9)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,144,277.5	20,143,620.1	(657.4)
Дүн	326,512,984.0	177,620,232.6	(148,892,751.4)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 177,620.2 сая төгрөг болж, 148,892.8 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө оруулалт төсвийн ерөнхийлөн захирагчид шилжсэнээс шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 160,136.0 сая

төгрөгөөр буурч, хуримтлагдсан үр дүн 17,484.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

3.4.9 Нийт орлого

Нийт орлого санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 104,778.5 сая төгрөгийн тайлант оны гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 9. Орлогын гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
Үйл ажиллагааны орлого	265,777,268.4	104,755,205.3	(161,022,063.1)
Үйл ажиллагааны бус орлого	-	23,325.0	23,325.0

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

-Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болж байгаа орлогыг төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөнд батлуулаагүй /Баянхонгор аймгийн БТСГ 111.3 сая төгрөг, Дундговь аймгийн БТСГ 4.7 сая төгрөг Налайх дүүргийн БТСХ 5.6 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн БТСХ 218.5 сая төгрөг, БТСУХ 196.8 сая төгрөг/

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогоос эрх бүхий байгууллагын шийдвэргүй зарцуулсан /Өмнөговь аймгийн БТСГ 15.5 сая төгрөг/.

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй спорт заалыг бусдад түрээслүүлсэн орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, төсөвт төвлөрүүлээгүй /Хөвсгөл аймгийн БТСГ 3.8 сая төгрөг, Ховд аймгийн БТСГ 8.4 сая төгрөг/

Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын 2023 оны 3 дугаар сарын 29-ний А/06 тоот тушаалаар баталсан "Төлбөртэй үйлчилгээний журам, үйлчилгээний төрөл, үнийн жагсаалт батлах тухай" журмыг мөрдөхгүй байгаагаас орлого дутуу төвлөрүүлэх эрсдэлтэй байна /Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв/

3.4.10 Нийт зардал

Нийт зардал санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 87,294.3 сая төгрөгийн тайлант оны гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 10. Зардлын гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
Үйл ажиллагааны зардлын дүн	82,503,519.3	86,705,459.3	4,201,940.0
Үйл ажиллагааны бус зардлын дүн	3,028,103.8	588,890.1	(2,439,213.7)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны иж бүрдэл дутуу баримтаар 56.6 сая төгрөгийг зарцуулсан /Булган аймгийн БТСГ 0.6 сая, Баянгол дүүргийн БТСХ 1.0 сая, Сонгинохайрхан дүүргийн БТСХ 3.0 сая, Увс аймгийн БТСГ 4.8 сая, Дундговь аймгийн БТСГ 5.0 сая, Архангай аймгийн БТСГ 10.2 сая, Ховд аймгийн БТСГ 31.4 сая/
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 35.8 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон /Ховд аймгийн БТСГ 15.3, Говьсүмбэр аймгийн БТСГ 6.9 сая, Хан-уул дүүргийн БТСХ 2.7 сая,

БТСУХ 2.4 сая, Булган аймгийн БТСГ 2.4 сая, Хэнтий аймгийн БТСГ 1.5 сая, Дархан-уул аймгийн БТСГ 1.5 сая, Баян-Өлгий аймгийн БТСГ 1.5 сая, Дорнод аймгийн БТСГ 1.3 сая, Хөвсгөл аймгийн БТСГ 0.3 сая, Хэнтий аймгийн БТСГ 0.2 сая, Булган аймгийн БТСГ 0.2 сая/

- *Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг 23.8 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож, тайлагнасан /Нийслэлийн БТСГ 10.7 сая, Хэнтий аймгийн БТСГ 3.6 сая, Хөвсгөл аймгийн БТСГ 3.3 сая, Орхон аймгийн БТСГ 2.4 сая, Архангай аймгийн БТСГ 1.0 сая, Баян-өлгий аймгийн БТСГ 1.0 сая, Дорноговь аймгийн БТСГ 0.8 сая, Говьсүмбэр аймгийн БТСГ 0.7 сая, Булган аймгийн БТСГ 0.2 сая/*
- *Төсвийг зориулалт бус, үрэлгэн 1,430.1 сая төгрөгийг зарцуулсан байна /Биеийн тамир, спортын улсын хороо 961.5 сая, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв 33.9 сая, Чингэлтэй дүүргийн БТСХ 238.7 сая, Сүхбаатар дүүргийн БТСХ 68.5 сая, Сонгинохайрхан дүүргийн БТСХ 14.8 сая, Налайх дүүргийн БТСХ 12.5 сая, Завхан аймгийн БТСГ 10.7 сая, Орхон аймгийн БТСГ 2.1 сая, Хэнтий аймгийн БТСГ 0.5 сая, Өмнөговь аймгийн БТСГ 0.1 сая /*
- *Ахмадын санг зохих журмаар байгуулаагүй, сангаас зориулалт бус зарцуулалт хийсэн 28.8 сая төгрөгийн зөрчил гаргасан /БТСУХ 25.4 сая, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв 1.7 сая, Чингэлтэй дүүргийн БТСХ 1.0 сая, Налайх дүүргийн БТСХ 0.8 сая/*
- *БТСУХ зохих журмын дагуу дотоод хяналт хэрэгжүүлээгүй 15,409.3 сая төгрөгийн зардал гаргасан.*
- *Нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналттай холбоотой 24.6 сая төгрөгийн зардлыг зарцуулсан /Чингэлтэй дүүргийн БТСХ 10.8 сая, Багануур дүүргийн БТСХ 13.9 сая/*
- *Томилолтыг 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон /Багануур дүүргийн БТСГ/*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд 99,963.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 136,213.8 сая төгрөг нийт 236,177.4 сая төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын засгийн газрын бүтцийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд шилжсэнээр биеийн тамир спортын салбарын зөвхөн урсгал үйл ажиллагааны санхүүжилт болох 72,395.8 сая төгрөг батлагдаж ирсэн бөгөөд төсвийн төсөлд хүргүүлсэн саналаас 27,567.8 сая төгрөгөөр буурсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн урсгал үйл ажиллагааны 2024 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 72,395.8 сая төгрөгөөр баталсан. Үүнээс Биеийн тамир, спортын улсын хороонд 42,927.6 сая төгрөг, аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газарт 26,938.8 сая төгрөг, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвд 1,341.9 сая төгрөг, Спортыг дэмжих санд 1,187.5 сая төгрөг буюу нийт 72,395.8 сая төгрөгийн төсөв баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 69,422.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 228.8 сая төгрөгийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого олж, нийт 69,651.5 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс 67,411.2 сая төгрөгийг зарцуулж, 2,059.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардал 67,411.2 сая төгрөг буюу 93.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Үүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 20,166.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,479.1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 226.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 333.3 сая төгрөг, нормативт зардал 1,509.3 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 2,328.5 сая төгрөг, томилолт зочны зардал 67.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 29,109.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 6,327.9 сая төгрөг, урсгал шилжүүлэг 4,864.3 сая төгрөгөөр зардал тус тус гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 52.0 сая төгрөг, улс орон нутгийн нөөц хөрөнгөөс 5,571.9 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 5,428.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,936.2 сая төгрөг, нийт 12,988.5 сая төгрөгийн орлого бүрдүүлснээр тайлагнасан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 1,910.6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 16.2 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 140.5 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 297.9 сая төгрөг, томилолт, зочны зардалд 8.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,789.0 сая төгрөг, бусад зардалд 7,915.9 сая төгрөг нийт 12,724.5 сая төгрөгийг зарцуулж, 264.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлснээр тайлагнасан байна.

Нэгтгэсэн нэмэлт болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлантай холбоотой мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл, зарцуулах эх үүсвэр, нийт зарлага цэвэр зээлийн дүн, нийт цэвэр мөнгөн гүйлгээний үзүүлэлтүүд 5,363.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. Үүнийг тодруулахад Нийслэлийн БТСГ-ын нэмэлт санхүүжилтэд улсын төсвөөс санхүүжих 8.0 сая төгрөг, Завхан аймгийн БТСГ-ын нэмэлт санхүүжилтэд 150.0 сая төгрөгийг тус тус зөрүүтэй нэгтгэсэн болон 5,182.1 сая төгрөгийн эхний үлдэгдэл хөрөнгө оруулалт, барьцаа данс төсвийн ерөнхийлөн захирагчид шилжсэнтэй холбоотой гэсэн тайлбар өгч залруулга хийсэн боловч хангалттай, зохистой нотлох баримт ирүүлээгүй тул дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын сайдын эрхлэх

асуудлын хүрээнд спортын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тайлант онд санхүүжих дүн 71,853.4 сая төгрөг бүхий 44 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

Монгол Улсын засгийн газрын бүтцийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Биеийн тамир, спортын улсын хорооны хөрөнгө оруулалтын данс, барьцаа баталгаа, техник хяналтын дансыг Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд 2024 оны 9 дүгээр сард шилжүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Биеийн тамир спортын улсын хороо, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг хангах, төсөвт зохицуулалт хийхдээ журам зааврыг баримтлах, зардлыг зөв ангилан бүртгэх, үйл ажиллагааны орлогыг төлөвлөх, холбогдох журам зааврыг сайжруулах, мөрдөж ажиллах, батлагдсан бүтэц орон тоог бүрдүүлэх, биет бус хөрөнгийн бүртгэл, хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсүх, аудитор Б.Батхишиг нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 3/157 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 85,531.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 855.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд төлөвлөөгүй бөгөөд гүйцэтгэлээр зарцуулалт гараагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар байгууллага нь албан хаагчдад хэмнэлтийн горимд шилжин ажиллах талаар үүрэг чиглэл өгч, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө тусган өр төлбөрийг барагдуулах, бичиг хэрэг, ашиглалтын зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Нийт 4,984.6 сая төгрөгийн хэмнэлт үүссэн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,155.5 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 186.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 13.8 сая төгрөг, нормативт зардал 268.7 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 44.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,834.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,445.9 урсгал шилжүүлэг 26.0 сая төгрөгөөр зардал тус тус хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Түүврийн байгууллага

Биеийн тамир, спортын улсын хорооны аппарат

Тус байгууллага нь шилэн дансны мэдээллийн санд 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого санхүүжилтийн 176 гүйлгээг хугацаа хоцроосон, зарлагын 7,211.2 сая төгрөгийн 118 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: ...6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээллийг байршуулаагүй, хуулиар хүлээсэн олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв шилэн дансны мэдээллийн санд 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 402.3 сая төгрөгийн 16 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: ...6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээллийг байршуулаагүй, хуулиар хүлээсэн олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах санхүүгийн удирдлагыг сайжруулах зөвлөмж өгсөн.

Аудитын илрүүлэлт:

- Хан-Уул дүүргийн БТСХ нь шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 178.3 сая төгрөгийн худалдан авалтыг 13 байгууллагатай хийснийг мэдээлээгүй

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Биеийн тамир, спортын хорооны харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 1,157.1 сая төгрөгийн 32 зөрчил илэрснээс 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 262.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 893.7 сая төгрөгийн 28 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл болон худалдан авах ажиллагаа зэрэг нийцлийн асуудал нь Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

-Холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийцлийн аудитын дүнгээр /Баянхонгор аймгийн БТСГ 111.3 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн БТСГ 2.5 сая төгрөг, Өмнөговь аймгийн БТСГ 3.9 сая төгрөг, Ховд аймгийн БТСГ 40.0 сая төгрөг, Нийслэлийн БТСГ 448.6 сая төгрөг, Багануур дүүргийн БТСХ 3.8 сая төгрөг, Багахангай дүүргийн БТСХ 26.1 сая төгрөг, Баянгол дүүргийн БТСХ 8.9 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн БТСХ 112.9 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн БТСХ 11.5 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн БТСХ 73.0 сая төгрөг/

Түүврийн байгууллага

Биеийн тамир, спортын хорооны хөдөлмөрийн аюулгүй байдлын хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдалд төсвийн хөрөнгийн 0.5 хувиас доошгүй хөрөнгийг төлөвлөж ажиллаагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2."Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, ...доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн аюулгүй байдалд төсвийн хөрөнгийг төлөвлөж байх зөвлөмж хүргүүлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Биеийн тамир, спортын улсын хорооны завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн 1,172.6 сая төгрөгийн 1 төлбөрийн актын хэрэгжилт 80.0 хувь, 12,066.9 сая төгрөгийн 4 зөвлөмжийн биелэлт 100.0 хувьтай хэрэгжсэн байна. Төлбөрийн актын дутуу төлөлтийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг шилжүүлсэн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үед горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо		Хувь
Акт	1	1,172,564.5	1	938,051.6	80.0
Зөвлөмж	4	12,066,900.0	4	12,066,900.0	100.0
Нийт дүн	5	13,239,464.5	5	13,004,951.6	96.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төвлөрүүлэн захирагчийн төсөвт баталсан боловч Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжсэн хөрөнгө оруулалт, захиалагчийн хяналт, барьцаа дансны гүйцэтгэл, Үндэсний шигшээ багийн санхүүгийн дэмжлэгийн дотоод аудитаар илэрсэн маргаантай асуудлууд энэ аудитын хүрээнд цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж аудит хийх боломжгүй нөхцөл үүсгэж байна. Мөн МУЗГ-ын 2024 оны 110 дугаар тогтоолоор Спортыг дэмжих санг хариуцахаар тогтоосон боловч санхүүгийн тайлан гаргаж байгаагүй, үйл ажиллагаа нь бүрэн зогссон, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хариуцан удирдах үүргээ хэрэгжүүлээгүй хэвээр байгаа асуудлуудыг дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

Нэгтгэсэн нэмэлт болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлантай холбоотой мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл, зарцуулах эх үүсвэр, нийт зарлага цэвэр зээлийн дүн, үзүүлэлтүүд 5,363.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байгааг төсвийн ерөнхийлөн захирагчид хөрөнгө оруулалт, барьцаа данс шилжсэнтэй холбоотой гэсэн тайлбар өгсөн тул дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 48,162.1 сая төгрөгийн 42 алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

Залруулсан алдаа: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд мэдээллийг тусгахгүй орхигдуулсан 41,142.4 сая төгрөгийн 1 алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

- БТСУХ-ны төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээ зориулалтаар нь бүрэн гаргаж тайлагнаагүй.

Залруулсан алдаа: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4,542.1 сая төгрөгийн 38 алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн байна. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн БТСГ-т 3.9 сая төгрөг,
- Говь-Алтай аймгийн БТСГ-т 39.1 сая төгрөг,
- Дорноговь аймгийн БТСГ-т 951.1 сая төгрөг,
- Дундговь аймгийн БТСГ-т 32.5 сая төгрөг,
- Орхон аймгийн БТСГ-т 33.9 сая төгрөг,
- Өвөрхангай аймгийн БТСГ-т 17.7 сая төгрөг,
- Өмнөговь аймгийн БТСГ-т 1,538.3 сая төгрөг,
- Төв аймгийн БТСГ-т 216.6 сая төгрөг
- Ховд аймгийн БТСГ-т 21.1 сая төгрөг,
- Хөвсгөл аймгийн БТСГ-т 1,549.6 сая төгрөг,
- Нийслэлийн БТСГ-т 138.2 сая төгрөг,

Түүврийн байгууллагад 2,477.5 сая төгрөгийн мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой 3 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд

- БТСУХ төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахдаа хөтөлбөр, арга хэмжээгээр бүрэн тайлагнаагүй, санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үйл ажиллагааны нийт үр дүн Санхүүгийн байдлын тайлангаарх эхний үлдэгдлийн тайлант оны үр дүнгээс 1,929.9 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв 547.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн тайланг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу бэлтгэж ирүүлээгүй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 18,667.7 сая төгрөгийн 106 зөрчил илэрснээс 61.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 24 төлбөрийн акт тогтоож, 16,561.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 28 албан шаардлага хүргүүлж, 2,044.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, санхүүгийн удирдлагыг сайжруулах 54 зөвлөмжийг хүргүүлсэн.

Залруулагдаагүй 18,667.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг бөгөөд мөн өргөн тархсан тул “**Сөрөг**” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа орон нутгийн байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 35 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 18 байгууллагад

дүгнэлт гаргаж, 15 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан, 2 байгууллага дараах шалтгаанаар аудитад хамрагдаагүй.

Спортыг дэмжих сан төсөв батлагдсан ч гүйцэтгэл гараагүй, биеийн тамир спортын улсын хорооны хөрөнгө оруулалт шинэ бүтэц зохион байгуулалтаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжсэн шалтгаанаар тус тус энэхүү аудитад хамрагдаагүй.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 16 дүгнэлт, Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газар болон Ховд аймгийн Биеийн тамир, спортын газарт “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт нийт 1,341.3 сая төгрөгийн 87 зөрчил илэрснээс 57.7 сая төгрөгийн 21 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 510.4 сая төгрөгийн 21 зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 773.2 сая төгрөгийн 45 зөрчлийг арилгах, арилгах санхүүгийн удирдлагыг сайжруулах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Албан шаардлага

1. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар 15,409.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг улсын төсвөөс олгосон боловч гэрээний биелэлтийг спортын холбоод бүрээр дүгнэж баталгаажуулаагүй, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс болон хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсээс гүйцэтгэлийг дүгнэж, баталгаажуулаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. Мөн хэлэлцүүлэг, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг зардлын гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ын 4.7 "Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, спортын холбооны хооронд байгуулсан энэ журмын 4.4-т заасны дагуу байгуулах гэрээ нь тухайн төсвийн жилд хэрэгжих бөгөөд гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэсний үндсэн дээр нэг жилээр сунгана", 4.15 "Ажлын хэсэг нь спортын холбоотой байгуулсан тухайн жилийн гэрээг дүгнэж, үйл ажиллагааны аудитын тайланг хэлэлцсэний үндсэн дээр энэ журмын дагуу олгох санхүүжилт, багийн орон тоог нэмэгдүүлэх болон бууруулах талаар дүгнэлтийг гаргана", 4.22 "Биеийн тамир, спортын улсын хорооны Хяналт шалгалтын нэгжээс эрсдэлийн үнэлгээнд суурилсан санхүүгийн болон үйл ажиллагааны шалгалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сонгогдсон спортын холбоодод жил бүр хийх үүрэгтэй", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Спортын холбоодод улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээний биелэлтийг хууль, журамд заасны дагуу хагас, бүтэн жилээр хянаж, баталгаажуулаагүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн буюу бусад хууль тогтоомжийн асуудалтай холбоотой 8,770.6 сая төгрөгийн, санхүүгийн 18,667.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4 "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж харьяа 10 байгууллага 422.9 сая төгрөгийг зарцуулсан байна. /Биеийн тамир, спортын улсын хороо, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газар, Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газар, Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газар, Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газар, Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар, Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газар, Хэнтий аймгийн Биеийн тамир, спортын газар/

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг санхүүжүүлэх", "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14 дүгээр зүйлийн 14.4 "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3 хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй, дотоод хяналт хангалттай хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулан алдаа, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Түүврийн байгууллага

5.3.1 Төлбөрийн акт

1. Биеийн тамир спортын улсын хорооны дарга нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2.4 сая төгрөгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Биеийн тамир спортын улсын хорооны ахмадын тэмдэглэлт өдөр, цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан ахмад настнуудад зориулан хүндэтгэл үзүүлэхдээ өөрийн байгууллагаас тэтгэвэрт гараагүй ахмадын нэрсийг оруулж тооцсоноос 0.6 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Жил бүрийн Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна”, 12.5 “Ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь дампуурсан буюу татан буугдсан болон бусад шалтгаанаар харьяалах аж ахуйн нэгж, байгууллага байхгүй болсон ахмад настныг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, бүртгэж Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн холбогдох ажилтнууд хувийн автомашинд 1.1 сая төгрөгийн шатахуун олгож, төсвийг зориулалтын бусаар зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “үр ашигтай байх”, 4.1.9 “хариуцлагатай байх” 4.2.1 “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах” Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.3.2 Албан шаардлага

1. Биеийн тамир, спортын улсын хороо Олон улсын хүүхдийн спортын 10 дугаар наадмын төсөвт тусгагдаагүй тоног төхөөрөмж, хэрэглэл, материалыг худалдан авахад 15.0 сая төгрөг, түрээсээр тоног төхөөрөмж ашигласны төлбөрт 19.8 сая төгрөг, чөлөөт бөхийн үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаагүй 42 хүнийг дотоодын бэлтгэл цугларалтад оролцуулсан байр, хоолны төлбөрт 148.1 сая төгрөг, ширээний теннисний үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаагүй 10 хүнийг дотоод бэлтгэл цугларалтад оролцуулсан байр, хоолны төлбөрт 33.9 сая төгрөг, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээнд тусгагдаагүй 34.0 сая төгрөгийн зардлыг сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн уралдаант тэмцээнд, 280.4 сая төгрөгийг "Гимнастрада-2024" Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд, 84.3 сая төгрөгийг тамирчдын эмчилгээ, сувилгаанд төсвийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ын 4.1 "Спортын холбоонд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Биеийн тамир спортын улсын хороо ахмадын санг зохих журмын дагуу байгуулаагүй боловч уг сангийн зориулалтыг үндэслэн байгууллагын төсөвт зардлаас 24.8 сая төгрөгийн зардлыг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.7 "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-д заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 3 дугаар бүлгийн 3.12 "Төсвийн байгууллагын удирдлага нь ахмадын сан байгуулан ажиллуулах тухай тушаалыг баталж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт хүргүүлж, ахмадын сангийн дансыг нээлгэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож арилгах, ахмадын санг зохих журмын дагуу байгуулах албан шаардлага хүргүүлсэн.

3. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв 1.7 сая төгрөгийн зардлыг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 24 дүгээр зүйлийн 24.7 “Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-д заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно”, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 3 дугаар бүлгийн 3.12 “Төсвийн байгууллагын удирдлага нь ахмадын сан байгуулан ажиллуулах тухай тушаалыг баталж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт хүргүүлж, ахмадын сангийн дансыг нээлгэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож арилгах, ахмадын санг зохих журмын дагуу байгуулах албан шаардлага хүргүүлсэн.

4. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын 2023 оны 3 дугаар сарын 29-ний А/06 дугаар тушаалаар баталсан “Төлбөртэй үйлчилгээний журам, үйлчилгээний төрөл, үнийн жагсаалт батлах тухай” журмыг мөрдөхгүй байгаагаас орлого дутуу төвлөрүүлэх эрсдэлтэй байгаа талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 “шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

5.3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Түүврийн байгууллага

5.3.3.1. Төсвийн төлөвлөлт, орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Биеийн тамир спортын улсын хороо заалны болон бусад түрээсээр 196.8 сая төгрөгийн орлого олж үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлого дансанд тайлагнасан боловч туслах үйл ажиллагааны орлогыг тухайн жилийн төсөвт

тусгаагүй, тухайн орлогыг олохтой холбоотой бус албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардалд 86.9 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 "Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөж зохих журмын дагуу НББ-д тусган уг орлогыг олоход гарсан зардалд зориулж зарцуулж байх.

5.3.3.2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Биеийн тамир спортын улсын хороо төсвийн захирагчийн мөнгөн гүйлгээний зарцуулалтыг нэгдсэн цахим системийн дүнтэй тулган шалгахад 46.8 сая төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14."төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг; 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэгдсэн цахим системийн дүнгээс зөрүүтэй гүйлгээг тухай бүр тулгалт хийн илрүүлж шалтгааныг тодруулж шийдвэрлэж байх.

5.3.3.3. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: БТСУХ Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 561.7 сая төгрөгийн авлага барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тухай бүрд тооцож үүсгэхгүй төсвийг зохистой удирдах.

5.3.3.4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Биеийн тамир спортын улсын хорооны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 35 төрлийн 1,904.7 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах болон дахин үнэлүүлэн, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох", УСНББОУС 17-д Үндсэн хөрөнгө дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрд хөрөнгийн бодит үнэ цэнэ, ашиглалтын хугацааг тооцож үздэг байх, шаардлагатай бол хөрөнгийг дахин үнэлэх, мөн тус стандартын Элэгдүүлэх дүн ба элэгдүүлэх хугацаа

хэсэгт “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой” заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг ашиглах болон дахин үнэлүүлж хөрөнгийг бодит үнэн цэнээр тайлагнаж байх.*

5.3.3.5. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: 1. Биеийн тамир спортын улсын хороо үндэсний шигшээ багийн холбоодын цалин нийгмийн даатгалтай холбоотой өр төлбөр хэдэн төгрөг нь тодорхой бус байхад санхүүжилтэд нөлөөлүүлээгүй, чөлөөт бөхийн үндэсний шигшээ багийн тамирчдад улсын төсвөөс санхүүжүүлэх журамд тусгагдаагүй тэмцээний дараах сэргэлтийн бэлтгэлд 86.9 сая төгрөгийг, нэр бүхий тамирчдын эмчилгээний зардалд 40.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны А/22 тоот тушаал Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам 4.1. "Спортын холбоонд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх: 4.1.1. Бэлтгэл хийх заал, танхим болон түрээсийн төлбөр, 4.1.2. Бэлтгэлийн хувцас, 4.1.3. Тэмцээний хувцас, 4.1.4. Спортын хэрэглэл, материал, 4.1.5. Эм, витамин, тариа, боолт хэрэгсэл, нэмэлт бүтээгдэхүүн, 4.1.6. Эмнэлгийн үзлэг, оношилгоо, 4.1.7. Сургалт, сорил, судалгаа, 4.1.8. Даатгал, 4.1.9. Дотоодын бэлтгэл цугларалт, 4.1.10. Гадаадын бэлтгэл цугларалт, 4.1.11. Олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцох зардал, 4.1.12. Засгийн газраас тогтоосон цалин, урамшуулал" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Үндэсний шигшээ багийн санхүүжүүлэх журмыг боловсронгуй болгох, тамирчдын зарцуулах зардлын эдийн засгийн ангиллыг төсвийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн хянах боломжтойгоор илүү тодорхой болгож, зардал тус бүрээр үнэн зөв тайлагнадаг болох*

Илрүүлэлт: 2. Биеийн тамир спортын улсын хороо байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримтат киноны уран бүтээлд 90.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн хууль 15 дугаар зүйл 15.1.4. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хэмнэж болох бусад зардлуудыг хэмнэж ажиллах*

Илрүүлэлт: 3. Төсвийн захирагч 128.0 сая төгрөгийн бараа материал худалдан авахдаа цахим дэлгүүрт тайлант оны худалдан авалтын захиалга, хүсэлтийг хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: *Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх, худалдан авалтын захиалга хүргүүлэн төсвийн зардлыг хэмнэж ажиллах*

Илрүүлэлт: 4. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв тайлант онд 32.8 сая төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал зөрчиж, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж /210801/ зардлын данснаас шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв төлөвлөж бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөрөөс гүйлгээ хийхгүй байх*

Илрүүлэлт: 5. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв ажилтан, албан хаагчдын ашиглаж буй эд хөрөнгийг дахин давтагдашгүй кодоор бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллаагүй бөгөөд өмчийн хадгалалт, хамгаалалт, хяналтын зохион байгуулалт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 67 дугаар зүйл "Дотоодын хяналт шалгалт 67.1-т Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", "67.2-т Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна"; гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: *Албан хаагчдын ашиглаж буй эд хөрөнгийг дахин давтагдашгүй кодоор бүртгэлжүүлэн, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой		Математик тооцоололтой холбоотой		НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Үүнээс залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баян-Өлгий аймгийн БТСГ	1	3,940.1	-	-	-	-	-	-	1	3,940.1	1	3,940.1
Говь-Алтай аймгийн БТСГ	3	39,118.6	2	37,668.6	1	1,450.0	-	-	-	-	3	39,118.6
Дорноговь аймгийн БТСГ	6	951,052.0	1	102,074.3	2	845,264.4	2	2,528.6	1	1,184.7	6	951,052.0
Дундговь аймгийн БТСГ	3	32,477.6	1	1,498.0	1	652.1	-	-	1	30,327.4	3	32,477.6
Орхон аймгийн БТСГ	1	33,999.2	-	-	1	33,999.2	-	-	-	-	1	33,999.2
Өвөрхангай аймгийн БТСГ	2	17,702.7	-	-	2	17,702.7	-	-	-	-	2	17,702.7
Өмнөговь аймгийн БТСГ	9	1,538,340.1	-	-	-	-	-	-	9	1,538,340.1	9	1,538,340.1
Төв аймгийн БТСГ	6	216,612.5	-	-	6	216,612.5	-	-	-	-	6	216,612.5
Ховд аймгийн БТСГ	2	21,083.4	1	16,912.2	1	4,171.2	-	-	-	-	2	21,083.4
Хөвсгөл аймгийн БТСГ	3	1,549,632.2	2	1,523,832.2	1	25,800.0	-	-	-	-	3	1,549,632.2
Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	2	138,190.3	1	11,614.0	1	126,576.3	-	-	-	-	2	138,190.3
Харьяа байгууллагын дүн	38	4,542,148.7	8	1,693,599.3	16	1,272,228.5	2	2,528.6	12	1,573,792.3	38	4,542,148.7
Биеийн тамир спортын улсын хороо	2	1,929,952.2	2	1,929,952.2	-	-	-	-	-	-	2	1,929,952.2
Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	1	547,556.6	1	547,556.6	-	-	-	-	-	-	1	547,556.6
Түүврийн байгууллага дүн	3	2,477,508.8	3	2,477,508.8	-	-	-	-	-	-	3	2,477,508.8
Биеийн тамир спортын улсын хорооны дарга	1	41,142,418.2	1	41,142,418.2	-	-	-	-	-	-	1	41,142,418.2
Нийт дүн	42	48,162,075.7	12	45,313,526.3	16	1,272,228.5	2	2,529.6	12	1,573,792.3	42	48,162,075.7

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Архангай аймгийн БТСГ	3	11,160.6	1	996.2	1	10,164.4	1	-
Баян-Өлгий аймгийн БТСГ	2	2,425.1	1	954.0	1	1,471.1	-	-
Булган аймгийн БТСГ	5	3,351.7	2	728.0	1	2,207.8	2	415.9
Говь-Алтай аймгийн БТСГ	1	5,559.6	-	-	1	5,559.6	-	-
Говьсүмбэр аймгийн БТСГ	2	7,580.8	1	6,867.9	-	-	1	712.9
Дархан-Уул аймгийн БТСГ	1	1,471.0	-	-	1	1,471.0	-	-
Дорноговь аймгийн БТСГ	1	816.1	-	-	1	816.1	-	-
Дорнод аймгийн БТСГ	2	3,123.9	-	-	2	3,123.9	-	-
Дундговь аймгийн БТСГ	2	9,726.0	2	9,726.0	-	-	-	-
Завхан аймгийн БТСГ	1	10,677.4	-	-	-	-	1	10,677.4
Орхон аймгийн БТСГ	4	4,454.0	4	4,454.0	-	-	-	-
Өмнөговь аймгийн БТСГ	8	255,982.4	-	-	6	240,382.4	2	15,600.0
Сүхбаатар аймгийн БТСГ	3	-	-	-	-	-	3	-
Төв аймгийн БТСГ	5	6,182.1	1	500.0	-	-	4	5,682.1
Увс аймгийн БТСГ	1	4,846.5	-	-	-	-	1	4,846.5
Ховд аймгийн БТСГ	3	55,058.7	2	23,618.7	-	-	1	31,440.0
Хөвсгөл аймгийн БТСГ	9	8,629.8	2	4,065.5	1	-	6	4,564.3
Хэнтий аймгийн БТСГ	4	5,766.0	3	4,295.0	1	1,471.0	-	-
Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	4	10,748.2	-	-	2	5,100.5	2	5,647.7
Багануур дүүргийн БТСХ	3	19,284.6	1	487.5	-	-	2	18,797.1
Багахангай дүүргийн БТСХ	2	24,632.0	-	-	1	-	1	24,632.0
Баянгол дүүргийн БТСХ	1	989.1	1	989.1	-	-	-	-
Налайх дүүргийн БТСХ	4	18,985.2	-	-	-	-	4	18,985.2
Сонгинохайрхан дүүргийн БТСХ	4	71,376.8	-	-	-	-	4	71,376.8
Сүхбаатар дүүргийн БТСХ	2	156,401.6	-	-	-	-	2	156,401.6
Хан-Уул дүүргийн БТСХ	4	57,034.9	-	-	-	-	4	57,034.9
Чингэлтэй дүүргийн БТСХ	6	585,039.0	-	-	2	238,650.5	4	346,388.5
Харьяа байгууллагын дүн	87	1,341,303.0	21	57,681.8	21	510,418.3	45	773,202.9
Биеийн тамир спортын улсын хороо	11	1,881,542.9	2	3,000.0	2	640,550.6	7	1,237,992.3
Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	5	35,573.1	1	1,100.0	2	1,653.9	2	32,819.2
Түүврийн байгууллагын дүн	16	1,917,116.0	3	4,100.0	4	642,204.5	9	1,270,811.5
Биеийн тамир, спортын улсын хорооны дарга	3	15,409,292.4	-	-	3	15,409,292.4	-	-
Нийт дүн	106	18,667,711.4	24	61,781.8	28	16,561,915.2	54	2,044,014.4

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянхонгор аймгийн БТСГ	2	111,274.9	-	-	-	-	2	111,274.9
Говьсүмбэр аймгийн БТСГ	1	2,500.0	-	-	-	-	1	2,500.0
Дархан-Уул аймгийн БТСГ	1	-	-	-	-	-	1	-
Дорноговь аймгийн БТСГ	1	-	-	-	1	-	-	-
Өмнөговь аймгийн БТСГ	1	3,850.0	-	-	-	-	1	3,850.0
Төв аймгийн БТСГ	2	-	-	-	-	-	2	-
Ховд аймгийн БТСГ	2	39,960.0	-	-	-	-	2	39,960.0
Хөвсгөл аймгийн БТСГ	2	-	-	-	-	-	2	-
Нийслэлийн БТСГ	4	448,607.0	1	544.4	1	262,910.0	2	185,152.6
Багануур дүүргийн БТСХ	2	3,825.3	-	-	-	-	2	3,825.3
Багахангай дүүргийн БТСХ	3	26,092.7	-	-	-	-	3	26,092.7
Баянгол дүүргийн БТСХ	2	8,881.8	-	-	-	-	2	8,881.8
Сонгинохайрхан дүүргийн БТСХ	2	112,978.3	-	-	-	-	2	112,978.3
Сүхбаатар дүүргийн БТСХ	2	11,498.2	-	-	-	-	2	11,498.2
Хан-Уул дүүргийн БТСХ	3	314,650.6	-	-	-	-	3	314,650.6
Чингэлтэй дүүргийн БТСХ	2	73,035.7	-	-	-	-	2	73,035.7
Харьяа байгууллагын дүн	32	1,157,154.5	1	544.4	2	262,910.0	29	893,700.1
Биеийн тамир спортын улсын хороо	2	7,211,185.4	-	-	1	7,211,185.4	1	-
Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	1	402,297.0	-	-	-	-	1	402,297.0
Түүврийн байгууллагын дүн	3	7,613,482.5	-	-	1	7,211,185.4	2	402,297.1
Нийт дүн	35	8,770,636.9	1	544.4	3	7,474,095.4	31	1,295,997.1

6.4 Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдалт

№	Шалгагдагч байгууллагын нэр	Аудитын код	Аудит хийсэн			Дүгнэлт					
			ҮАГ	АНАГ	АХЭ	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт гаргахаас татгалзах	Түүвэрт	Аудитад хамрагдаагүй
1	Архангай аймгийн БТСГ	АРА-2025/12/НА-СТА-ТШЗ		1		1					
2	Баян-Өлгий аймгийн БТСГ	БӨА-2025/031/НА-СТА-ТШЗ		1						1	
3	Баянхонгор аймгийн БТСГ	БНА-2025/042/НА-СТА-ТШЗ		1		1					
4	Булган аймгийн БТСГ	БУА-2025/066/НА-СТА-ТШЗ			1	1					
5	Говь-Алтай аймгийн БТСГ	ГАА-2025/056/НА-СТА-ТШЗ		1		1					
6	Говьсүмбэр аймгийн БТСГ	ГСА-2025/011/НА-СТА-ТШЗ			1	1					
7	Дархан-Уул аймгийн БТСГ	ДАА-2025/34/НА-СТА-ТШЗ		1						1	
8	Дорноговь аймгийн БТСГ	ДГА-2025/22/НА-СТА-ТШЗ		1						1	
9	Дорнод аймгийн БТСГ	ДОА-2025/069/НА-СТА-ТШЗ			1	1					
10	Дундговь аймгийн БТСГ	ДУА-2025/76/НА-СТА-ТШЗ		1						1	
11	Завхан аймгийн БТСГ	ЗАА-2025/068/НА-СТА-ТШЗ			1	1					
12	Орхон аймгийн БТСГ	ОРА-2025/081/НА-СТА-ТШЗ		1		1					
13	Өвөрхангай аймгийн БТСГ	ӨВА-2025/062/НА-СТА-ТШЗ			1	1					
14	Өмнөговь аймгийн БТСГ	ӨМА-2025/019/НА-СТА-ТШЗ		1			1				
15	Сүхбаатар аймгийн БТСГ	СБА-2025/004/НА-СТА-ТШЗ		1		1					
16	Сэлэнгэ аймгийн БТСГ	СЭА-2025/045/НА-СТА-ТШЗ		1		1					
17	Төв аймгийн БТСГ	ТӨА-2025/008/НА-СТА-ТШЗ			1	1					
18	Увс аймгийн БТСГ	УВА-2025/183/НА-СТА-ТШЗ			1	1					
19	Ховд аймгийн БТСГ	ХОА-2025/125/НА-СТА-ТШЗ		1			1				
20	Хөвсгөл аймгийн БТСГ	ХӨА-2025/185/НА-СТА-ТШЗ			1	1					
21	Хэнтий аймгийн БТСГ	ХЭА-2025/007/НА-СТА-ТШЗ			1	1					
22	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	НТАГ-2025/805/НА-СТА-ТШЗ			1	1					
23	Багануур дүүргийн БТСХ	НТАГ-2025/802/НА-СТА-ТШЗ		1						1	
24	Багахангай дүүргийн БТСХ	НТАГ-2025/803/НА-СТА-ТШЗ		1						1	
25	Баянгол дүүргийн БТСХ	НТАГ-2025/452/НА-СТА-ТШЗ		1						1	
26	Баянзүрх дүүргийн БТСХ	НТАГ-2025/804/НА-СТА-ТШЗ		1						1	
27	Налайх дүүргийн БТСХ	НТАГ-2025/453/НА-СТА-ТШЗ		1						1	
28	Сонгинохайрхан дүүргийн БТСХ	НТАГ-2025/806/НА-СТА-ТШЗ		1						1	
29	Сүхбаатар дүүргийн БТСХ	НТАГ-2025/454/НА-СТА-ТШЗ		1						1	

Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

30	Хан-Уул дүүргийн БТСХ	НТАГ-2025/807/НА-СТА-ТШЗ		1						1	
31	Чингэлтэй дүүргийн БТСХ	НТАГ-2025/808/НА-СТА-ТШЗ		1						1	
32	Биеийн тамир спортын улсын хороо	СНАГ-2025/403/НА-СТА-ТШЗ	1							1	
33	Спортыг дэмжих сан	СНАГ-2025/009/НА-СТА-ЗГТС	1								1
34	Биеийн тамир спортын улсын хорооны хөрөнгө оруулалт	СНАГ-2025/102/НА-СТА-ТШЗ	1								1
35	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	СНАГ-2025/266/НА-СТА-ТШЗ	1							1	
	Нийт дүн		4	21	10	16	2	0	0	15	2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 03 дугаар сарын 25

№ 192/20160050

Улаанбаатар хот

Схм-2025/403/НА-СТА-Тцз

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахмадын тэмдэглэлт өдөр, цагаан сарын баярийн өдрийг тохиолдуулан ахмад настнуудад зориулан хүндэтгэл үзүүлэхдээ өөрийн байгууллагаас тэтгэвэрт гараагүй ахмадын нэрсийг оруулж тооцсоноос 600,000.00 /зургаан зуун мянган/ төгрөг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Жил бүрийн Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна”, 12.5 “Ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь дампуурсан буюу татан буугдсан болон бусад шалтгаанаар харьяалах аж ахуйн нэгж, байгууллага байхгүй болсон ахмад настныг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, бүртгэж Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” -д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өөрийн байгууллагаас тэтгэвэрт гараагүй ахмадуудад олгосон 600,000.00 /зургаан зуун мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дах Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Билэгт/, Ерөнхий нягтлан бодогч /А.Өнөрцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.БАТСҮХ

ATA9693 9006109
9023030583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2025\0325 SNAG-4.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 03 дугаар сарын 25

№ 193/20160050

Улаанбаатар хот

СНДГ - 2025/403/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн дарга, ерөнхий нягтлан бодогч болон хуулийн мэргэжилтний хувийн автомашинд 1,100,000.00 /Нэг сая нэг зуун мянган / төгрөгийн шатахуун олгож, төсвийг зориулалтын бусаар зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “үр ашигтай байх”, 4.1.9 “хариуцлагатай байх” 4.2.1 “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн”-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Хувийн автомашинд олгосон шатахууны төлбөр 1,100,000.00 /Нэг сая нэг зуун мянган / төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга /Б.Эрдэнэваанчиг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Замхуулин





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 дугаар сарын 25

№ 194/2060050

Улаанбаатар хот

СНМ-2025/403/МЯ СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хорооны дарга нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2,400,000.00 /хоёр сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон 2,400,000.00 /хоёр сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Билэгт/, Ерөнхий нягтлан бодогч /А.Өнөрцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.БАТСҮХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 780/20160050

Улаанбаатар хот

СНТ-2025/403/НД-СТДТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахмадын санг зохих журмын дагуу байгуулаагүй боловч уг сангийн зориулалтыг үндэслэн байгууллагын төсөвт зардлаас 24,836,640.00 /Хорин дөрвөн сая найман зуун гучин зургаан мянга зургаан зуун дөчин/ төгрөгийн зардлыг гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.7 "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-д заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 3 дугаар бүлгийн 3.12 "Төсвийн байгууллагын удирдлага нь ахмадын сан байгуулан ажиллуулах тухай тушаалыг баталж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт хүргүүлж, ахмадын сангийн дансыг нээлгэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан -д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Билэгт/, ерөнхий нягтлан бодогч /А.Өнөрцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.БАТСҮХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 781/А0160050

Улаанбаатар хот

СНМ-2025/403/НА-СТД-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 7,211,185,320.60 /Долоон тэрбум хоёр зуун арван нэгэн сая нэг зуун наян таван мянга гурван зуун хорин/ төгрөгийн 118 гүйлгээг шилэн дансанд хугацаанд нь мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: ...6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Билэгт/, ерөнхий нягтлан бодогч /А.Өнөрцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.БАТСҮХ

ATA5693 95 6109
9023030583



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 782/20160050

Улаанбаатар хот

СНМ-2025/403/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын 2023 оны 3 дугаар сарын 29-ний А/06 дугаар тушаалаар баталсан "Төлбөртэй үйлчилгээний журам, үйлчилгээний төрөл, үнийн жагсаалт батлах тухай" журмыг мөрдөхгүй байгаагаас орлого дутуу төвлөрүүлэх эрсдэлтэй байгаа талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга /Б.Эрдэнэваанчиг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.БАТХИЦИГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 783/20160050

Улаанбаатар хот

СНДГ-2025/403/НА-СТД-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант хугацаанд ахмадын санг зохих журмын дагуу байгуулаагүй боловч уг сангийн зориулалтыг үндэслэн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлаас 1,653,940.00 /нэг сая зургаан зуун тавин гурван мянга есөн зуун дөчин/ төгрөгийн зардлыг гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.7 "төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-д заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно" Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 3 дугаар бүлгийн 3.12 "төсвийн байгууллагын удирдлага нь ахмадын сан байгуулан ажиллуулах тухай тушаалыг баталж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт хүргүүлж, ахмадын сангийн дансыг нээлгэнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" -д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ахмадын сан байгуулаагүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга /Б.Эрдэнэваанчиг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.БАТХИШИГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26423

ATA9693 9056109
9023030583

Z:\Alban Shaardlaga\2025\0325 SNAG-6.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 784/20160050

Улаанбаатар хот

СНМ-2025/403/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


- Биеийн тамир спортын улсын хорооны даргын 2024 оны А/414 дүгээр тушаалаар Олон улсын хүүхдийн спортын 10 дугаар наадмын төсөвт тусгагдаагүй тоног төхөөрөмж, хэрэглэл, материалыг худалдан авахад 15,000,000.00 /арван таван сая/ төгрөг, түрээсээр тоног төхөөрөмж ашигласны төлбөрт 19,800,000.00 /арван есөн сая найман зуун мянган/ төгрөг,
- Чөлөөт бөхийн үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаагүй 42 хүнийг дотоодын бэлтгэл цугларалтад оролцуулсан байр, хоолны төлбөрт 148,050,000.00 /Нэг зуун дөчин найман сая тавин мянган/ төгрөг;
- Ширээний теннисний үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаагүй 10 хүнийг дотоод бэлтгэл цугларалтад оролцуулсан байр, хоолны төлбөрт 33,988,888.88 /Гучин гурван сая есөн зуун наян найман мянга найман зуун наян найман/ төгрөг;
- Спортын холбоонд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг зөрчиж сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн "Хамтдаа хичээе-2024" уралдаант тэмцээнд 34,035,000.00 /гучин дөрвөн сая гучин таван мянган/ төгрөг, "Гимнастрада-2024" Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд 280,360,000.00 /хоёр зуун наян сая гурван зуун жаран мянган/ төгрөг, тамирчдын бэртэл, гэмтлийг эмчлэх, уламжлалт эмчилгээ, сувилгаанд 84,480,000.00 /наян дөрвөн сая дөрвөн зуун наян мянган/ төгрөгийг тус тус зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ын 4.1 "Спортын холбоонд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Билэгт/, ерөнхий нягтлан бодогч /А.Өнөрцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ЦААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.БАТСҮХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 785/АА60050

Улаанбаатар хот

СНМ-2025/018/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж харьяа 10 байгууллага 422,956,110.00 /Дөрвөн зуун хорин хоёр сая есөн зуун тавин зургаан мянга нэг зуун арван/ төгрөгийг зарцуулсан байна. /Биеийн тамир, спортын улсын хороо, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газар, Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газар, Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газар, Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газар, Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар, Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газар, Хэнтий аймгийн Биеийн тамир, спортын газар,/

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг санхүүжүүлэх", "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14 дүгээр зүйлийн 14.4 "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3 хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй дотоод хяналт хангалттай хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Билэгт/, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Н.Батсүх/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.БАТСҮХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 786/20160050

Улаанбаатар хот

СНМ- 0025/018/НА-СТА ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн 18,667,711,388.05 /арван найман тэрбум зургаан зуун жаран долоон сая долоон зуун арван нэгэн мянга гурван зуун наян найман/ төгрөг, нийцлийн аудитын 8,770,636,926.00 /найман тэрбум долоон зуун далан сая зургаан зуун гучин зургаан мянга есөн зуун хорин зургаан/ төгрөгийн нийт 27,438,348,314.05 /хорин долоон тэрбум дөрвөн зуун гучин найман сая гурван зуун дөчин найман мянга гурван зуун арван дөрвөн/ төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4 "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулан алдаа, зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулан ажиллаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Билэгт/, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Н.Батсүх/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.БАТСҮХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 787/А0160050

Улаанбаатар хот

С н м - 2025/018/нр-снз-тгз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тайлант оны эхний хагас жилийн байдлаар 15,409,292,418.35 /арван таван тэрбум дөрвөн зуун есөн сая хоёр зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун арван найман/ төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг улсын төсвөөс олгосон боловч гэрээний биелэлтийг спортын холбоод бүрээр дүгнэж баталгаажуулаагүй, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс болон хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсээс гүйцэтгэлийг дүгнэж, баталгаажуулаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. Мөн хэлэлцүүлэг, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг зардлын гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ын 4.7 "Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, спортын холбооны хооронд байгуулсан энэ журмын 4.4-т заасны дагуу байгуулах гэрээ нь тухайн төсвийн жилд хэрэгжих бөгөөд гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэсний үндсэн дээр нэг жилээр сунгана", 4.15 "Ажлын хэсэг нь спортын холбоотой байгуулсан тухайн жилийн гэрээг дүгнэж, үйл ажиллагааны аудитын тайланг хэлэлцсэний үндсэн дээр энэ журмын дагуу олгох санхүүжилт, багийн орон тоог нэмэгдүүлэх болон бууруулах талаар дүгнэлтийг гаргана", 4.22 "Биеийн тамир, спортын улсын хорооны Хяналт шалгалтын нэгжээс эрсдэлийн үнэлгээнд суурилсан санхүүгийн болон үйл ажиллагааны шалгалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сонгогдсон спортын холбоодод жил бүр хийх үүрэгтэй", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Спортын холбоодод улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээний биелэлтийг хууль, журамд заасны дагуу хагас, бүтэн жилээр хянаж, баталгаажуулаагүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Билэгт/, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Н.Батсүх/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.БАТСҮХ